

**БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ
ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ХИЙСЭН ТАЙЛАН**

АГУУЛГА

НЭГ. УДИРТГАЛ, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

2.1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд гаргасан журмын талаар:

2.2.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний бүтэц, тогтолцоо, зохицуулалтын хэрэгжилтийн байдал:

2.3.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд оролцогчдын эрх, үүргийн хэрэгжилт:

2.4.Нөлөөллийн үнэлгээний үйл ажиллагааны олон нийтийн оролцооны хэрэгжилт.

ГУРАВ.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

ТОВЧИЛСОН ҮГ

БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОНБҮ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОНБҮТ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай
БОННҮ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ХБОБНУГ	Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар
УИХ	Улсын Их Хурал
ТББ	Төрийн бус байгууллага
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл

НЭГ. УДИРТГАЛ, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (цаашид “БОНБҮТ” хууль гэх) нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулах зорилготойгоор Улсын Их Хурлаас 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр 5 бүлэг, 20 зүйлтэйгээр батлагдсан.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийхэд оролцогч талуудын үүрэг, хариуцлага тодорхой бус байгаагаас шалтгаалан байгаль орчин доройтох, байгалийн тэнцвэрт байдал алдагдах, нутгийн оршин суугч иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөх явдал гардаг учраас үнэлгээний үйл явцад олон нийтийн оролцоо, хяналтыг хангах асуудлыг шийдвэрлэх, үнэлгээний тайланд нутгийн иргэдийн саналыг авах, тусгах, олон нийтийн оролцоог хангах хэрэгцээ шаардлагын дагуу тус хуулийг шинэчлэн найруулсан. Мөн тус хууль батлагдсанаар байгаль орчны үнэлгээтэй холбогдох үйл ажиллагааны хамрах хүрээ, зохицуулалт, хяналт сайжрах, түүнчлэн байгаль орчинд аливаа сөрөг нөлөөлөл учрах, байгаль орчин бохирдон доройтохоос урьдчилан сэргийлэн, экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлэх нөхцөл бүрдэх зэрэг эерэг үр дагавар гарна гэж үзсэн.

Иймд Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ирүүлсэн саналын дагуу Хууль тогтоомжийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасан "...хууль тогтоомжийн зорилтыг хангаж байгаа түвшинг тодорхойлох, хууль тогтоомжийн үзэл баримтлалд тодорхойлсон үр дүнд хүрэх байдлыг тогтоох" чиглэлээр хяналт шинжилгээ хийнэ гэж заасан байх тул Улсын Их Хурлын Тамгын газраас БОНБҮТ хуулийн хэрэгжилтийн явцыг тодорхойлохоор хяналт шинжилгээг гүйцэтгэсэн болно.

Энэхүү хуулийн хяналт шинжилгээний ажлын зорилго нь БОНБҮТ хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал болон хууль анх батлагдан гарч байсан үеийн үзэл баримтлал, хуулийн зорилт, зорилгодоо хүрч чадаж байгаа эсэхийг судалж, цаашид хуулийн хэрэгжилтийг тогтвортой болгоход хувь нэмэр оруулах явдал юм.

Хуулийн хэрэгжилтийн явцад Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

БОНБҮТ хуулийн хэрэгжилтийн явцыг тодорхойлох, уг хуулийн зорилго, үзэл баримтлалаар тодорхойлсон үр дүнд хүрэх байдлыг тогтоох үүднээс хуулийн хэрэгжилтийн байдалд бүхэлд нь хяналт шинжилгээ хийж, тохирох хэмжүүрийг сонгон, холбогдох мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийсэн болно.

Хяналт шинжилгээний мэдээллийг Байгаль орчин аялал, жуулчлалын сайдын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 01/3987 дугаар албан бичиг, МХЕГ-аас цахимаар ирүүлсэн мэдээлэл, БОНБҮТ хуулийн үзэл баримтлал зэрэг албан эх сурвалж болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь: Оролцогч талуудын судалгаа”, статистик тоо зэрэг баримт бичгийн эх сурвалж, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд оролцогч субъектуудээс тэнцвэртэй мэдээлэл авах зорилгоор БОАЖЯ-ны Байгаль орчны үнэлгээ, Аудитын хэлтсийн ахлах шинжээч, Байгаль орчны

үнэлгээ эрхлэгчдийн холбоо ТББ, үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгжийн төлөөлөл, удирдлагатай уулзалт, ярилцлага зохион байгуулж хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг цуглуулсан.

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

2.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд гаргасан журмуудын талаар:

БОНБУТ хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газар, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас 5 журам, 2 аргачлал батлахаар хуульчилсан.

Эдгээрээс дараах журам, аргачлалыг баталж, холбогдох байгууллагууд үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:

БОНБУТ хуульд тусгагдсан журам, аргачлал	Хэрэгжилтийн байдал
5.3. Стратегийн үнэлгээ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний талаарх нарийвчилсан журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.
7.7. Нөлөөллийн үнэлгээний журам, аргачлалыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, аргачлалд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаа болон мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа, нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний талаарх зохицуулалтыг тусгана.	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-117 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, 2 дугаар хавсралтаар “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”-ыг тус тус батлан хэрэгжүүлж байна. - Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.
9.4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах болон нөхөн сэргээлт хийх журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нөхөн сэргээлтийн стандартыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага тус тус батална.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах болон хянан батлах, тайлагнах журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.
9.15. Энэ хуулийн 9.9, 9.10-т заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-04 дүгээр тушаалаар “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.
18.5. Олон нийтийн оролцооны асуудлыг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-03 дугаар тушаалаар “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.

2.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний бүтэц, тогтолцоо, зохицуулалтын хэрэгжилтийн байдал:

Мэргэжлийн зөвлөл: БОНБҮТ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний асуудлыг зохицуулах, энэ хуулийн 4.1.1, 4.1.4, 7.1.2-т заасан үнэлгээний үр дүн, тайланд дүгнэлт өгөх, үүрэг бүхий байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөл ажиллана” гэж заасан. Мэргэжлийн зөвлөлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр байгуулдан ажилладаг бөгөөд хууль хэрэгжиж эхэлснээс хойш яамны бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт болон ХБОБНУГ-ын дарга өөрчлөгдөх, Мэргэжлийн зөвлөлд ажиллаж буй бусад байгууллагын төлөөллийн албан тушаалтан өөрчлөгдөх, чөлөөлөгдөх зэргээс шалтгаалан нийтдээ 7 удаа Мэргэжлийн зөвлөлийн бүтцийг шинэчлэн баталсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хуулийн хэрэгжилттэй холбоотой ирүүлсэн мэдээлэлд тус Мэргэжлийн зөвлөлийн санхүүжилтэд 2013-2020 онд нийт 28.0 сая төгрөг зарцуулсан гэжээ. Тухайлбал, 2013-2018 онд 3.0 сая төгрөг, 2019-2020 онд 10.0 сая төгрөгийг Мэргэжлийн зөвлөлийн хурлыг зохион байгуулах, хурлын техник хэрэгсэл худалдан авах зэрэг зардалд зарцуулсан байна. Цаашид Мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн урамшууллын асуудлыг эргэн харж эдийн засгийн нөхцөл байдал, мөнгөний худалдан авах чадвартай нийцүүлэн шинэчлэн тогтоох нь зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, ажлын бүтээмжид эерэгээр нөлөөлөх талтай байна.

Мэргэжлийн зөвлөл хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж байгаа хэдий ч хэлэлцэх асуудлын тоо их, ачаалал их байдагтай холбоотой зарим хүндрэл бэрхшээл гарах, хуульд заасан хугацаатай чиг үүргүүдийн хэрэгжилт хангалтгүй байх нөхцөл бүрэлддэг байна. Тухайлбал, тус Мэргэжлийн зөвлөлийн хуралдах хуралдааны тов тодорхойгүй, удаан хугацааны турш хуралддаггүй зэргээс шалтгаалан төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж болон үнэлгээ эрхлэгчдийн улирлын чанартай ажилд цаг хугацаа алдах, үнэлгээний ач холбогдол буурах, улмаар эдийн засгийн хохирол хүлээх нэг нөхцөл болдог гэдгийг хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл цуглуулах хүрээнд мэргэжлийн холбоод, үнэлгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн төлөөллийн зүгээс илэрхийлж байсан.

Нөгөө талаас Мэргэжлийн зөвлөл цаг хугацаандаа тогтмол хуралддаг хэдий ч төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч болон үнэлгээ эрхлэгч нарын буруутай үйл ажиллагааны улмаас үнэлгээний тайлан, холбогдох материалаа цаг хугацаандаа бүрэн өгдөггүй, тодорхой шалтгаанаар буцаагдах зэргээс хугацаа хойшилж хэлэлцэх тохиолдол гардаг байна. Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэх асуудал, ажлын ачаалал зэргээс шалтгаалан хуульд заасан хугацаанд багтаан тайланг хянаж, дүгнэлт гаргах үйл ажиллагаа удааширдаг байна.

Мөн нарийвчилсан үнэлгээний тайлан болон эрх олгох, сунгах зэрэг асуудлууд Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэх ажлын жагсаалтад орсон боловч хуульд заасан хугацаанд амжихгүй байх, хурлаар хэлэлцүүлж чадахгүй үлдэх, түүнчлэн богино хугацаанд тайлантай танилцдаг тул төслийн үйл ажиллагаанд байгаа асуудал, бэрхшээлийг олж харахгүй орхигдуулах, асуудлаа хэлэлцүүлэх боломж хомс байх зэрэг асуудлууд тулгардаг байна.

Стратегийн үнэлгээ: Хуулийн 5 дугаар зүйлд улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад түүний хэрэгжилтээс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлага, гамшиг,

аюулт үзэгдэл, осол, аюултай уялдуулан тодорхойлох байгаль орчны стратегийн үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг зохицуулсан.

Тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, 5 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, 18 дугаар зүйлийн 18.1, 18.2, 18.3 дахь хэсгүүдэд стратегийн үнэлгээний тодорхойлолт, тус үнэлгээг хийх нарийвчилсан журам батлах, стратегийн үнэлгээг хийх, тайланг хэлэлцэж, дүгнэлтийг танилцуулах, олон нийтэд мэдээлэх, стратегийн үнэлгээнд хамрагдах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулсан байгууллага болон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг, үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хэрхэн хангах талаарх харилцааг зохицуулсан хэдий ч хэрэгжилт хангалтгүй байна.

Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам”-ыг баталсан байна.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойш стратегийн үнэлгээ хийгдээгүй бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хууль, холбогдох журам, аргачлал /2013-2014/ батлагдсаны дараа бүх төрийн захиргааны төв байгууллагын бодлого, хөтөлбөр хариуцсан удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудад стратегийн үнэлгээ хийх талаарх сургалтыг 2013, 2015, 2018 онуудад зохион байгуулж, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр, үндэсний хэмжээний төлөвлөгөө, төсөлд стратегийн үнэлгээ хийлгэх талаар Сайдын албан тоотыг тухай бүрт хүргүүлэн ажилласан байна.

Гэвч төрийн захиргааны төв байгууллагууд стратегийн үнэлгээг хийлгэх тал дээр маш хойрго хандаж, өнөөг хүртэл стратегийн үнэлгээ хийх хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа учир яамны зүгээс Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуультай нийцүүлэн БОНБУТ хууль, холбогдох үнэлгээний журам, аргачлалд нэмэлт, өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байна. Мөн тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт заасан “*Стратегийн үнэлгээний тайланг мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж, дүгнэлт гаргах бөгөөд уг дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газарт танилцуулна.*” гэж заасан хэдий ч стратегийн үнэлгээ хийгдээгүй төсөл, хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталж байна.

Стратегийн үнэлгээ хийгдэхгүй байгаа нь төрөөс улс орон, тодорхой бүс нутаг, салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлж, дунд болон урт хугацаанд хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тооцож байх, хөгжлийн бодлого, урт болон дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөнд байгаль орчны стратегийн үнэлгээ хийх, стратегийн үнэлгээний тайланд олон нийтийн санал авах гэсэн хуулийн төслийн үзэл баримтлалаар дэвшүүлсэн зорилго хангагдахгүй байгааг харуулж байна.

Төлөв байдлын үнэлгээ: Аливаа төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож, цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг байгаль орчны төлөв байдлын үнэлгээгээр тодорхойлдог.

Олон улсын жишгээр төсөл хэрэгжүүлэгч хэрэгжүүлэх төслийнхөө ТЭЗҮ, зураг төсөл гэх мэт баримт бичгүүдийг боловсруулахдаа байгаль орчны төлөв байдлын үнэлгээг хийлгэдэг бөгөөд үүнийг үндэслэн баримт бичгүүдээ боловсруулдаг. Гэвч одоогоор уг үнэлгээг баримт бичиг боловсруулах явцад хийж байгаа нь цаг хугацааны хувьд хоцорч хийгдэх, төсөл хэрэгжүүлэгчдэд ач холбогдол багатай баримт бичиг болох, түүнчлэн тус

тайлан нь чанар муутай, бүс нутгийн байгаль орчны ерөнхий мэдээллийг хуулсан баримт бичиг болж хувирсныг салбарын мэргэжилтнүүд шүүмжлэлтэй хандаж байна. Манай улсад батлагдсан ТЭЗҮ-тэй байж, дараа нь үнэлгээ хийнэ гэдэг шаардлага тавигдаж байгаа нь үнэлгээний ажлын дараалал алдагдах, түүний үр дүн, ач холбогдлыг бууруулах нөхцөл болдог байна.

Мөн БОНБҮТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасан “Эрх бүхий мэргэжлийн байгууллага нь боловсруулсан байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх үнэлгээний асуудал эрхэлсэн мэргэжлийн зөвлөлд хүргүүлж хянуулна.” гэсэн хэсгийн “мэргэжлийн зөвлөлд хүргүүлж, хянуулна” гэснийг “шүүмж хийлгэж, дүгнэлт гаргуулна” гэж өөрчилснөөр хууль зүйн үр дагаврыг нэмэгдүүлэх, үнэлгээний тайлангийн чанар, хүртээмж, үр дүнг нэмэгдүүлэх боломжтой гэдгийг холбогдох мэргэжлийн холбоод үзэж байна. Түүнчлэн байгаль орчны төлөв байдлын үнэлгээг төсөл, хөтөлбөр хэрэгжих тухайн талбайг нэрлэж хийдэг болсноор үнэлгээ бодитой, үр дүнтэй болох эерэг үр дагавартай болсон байна.

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ: Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслүүдээс хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа хам болон давхардмал сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоодог.

БОНБҮТ хууль хэрэгжиж эхэлснээс хойш өнөөг хүртэл нийт 4 удаа хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийсэн байна. Үүнд:

1. Заамрын алтны уурхайн бүс нутагт хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ /2014/;
2. Дорноговь аймгийн нутагт цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, газрын тос, ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа төмөр зам, авто замаас үзүүлэх хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ /2015/;
3. Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ /2019/;
4. Тавантолгойн нүүрсний уурхайн бүс нутагт хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ /2019/ тус тус хийжээ.

Эдгээр хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнээс Заамар, Багануур, Тавантолгойн нүүрсний уурхайн бүс нутгийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг БОАЖЯ-ны байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хүлээн авч Байгаль орчны мэдээллийн сан болох www.eic.mn цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулсан байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт “Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажилд шаардагдах зардлыг нөлөөллийн цар хүрээг харгалзан төсөл хэрэгжүүлэгчээс гаргуулна” гэж заасан. Монгол Улсын Засгийн газрын хүсэлтээр “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн хүрээнд БОАЖЯ-ны дэмжлэгтэйгээр Дэлхийн банкны 712.5 сая төгрөгийн санхүүжилтээр “Грийнтрэндс” ХХК-аас Тавантолгой ба Багануурын нүүрсний уурхайн бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн байна. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажилд шаардагдах зардлыг олон улсын байгууллагын санхүүжилтээр хийсэн нь төсөл хэрэгжүүлэгч үнэлгээний ажилд шаардагдах зардлыг гаргах гэсэн заалт бодит байдалд хэрэгжихгүй байгааг харуулж байна.


Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний цар хүрээ өргөн, төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжид эдийн засгийн хувьд ач холбогдолгүй, тухайн үнэлгээг зайлшгүй хийх эрх зүйн

хэрэгцээ шаардлага сул зэргээс шалтгаалан хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийгдэхгүй байх нөхцөл бүрдсэн гэж үзэж болохоор байна.

Байгаль орчны стратегийн үнэлгээ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ төдийлөн хийгддэггүй тул энэ хуулиар эдгээр үнэлгээтэй холбоотой харилцааг зохицуулах шаардлага байна уу, үгүй юу гэдгийг эргэн харах хэрэгтэй гэдэг саналыг үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хийсэн уулзалтын үеэр дурдаж байсан¹ болно.

Нөлөөллийн үнэлгээ: Нөлөөллийн үнэлгээ нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнээс бүрддэг. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны алба хийдэг.

Зураг 1. Батлагдсан ерөнхий үнэлгээний дүгнэлт
/2012 оноос хойш/



Эх сурвалж: <https://www.eic.mn/eia/> - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан

Үнэлгээний шинжээч ерөнхий үнэлгээг ажлын 14 хоногт багтаан гүйцэтгэж төслийг хэрэгжүүлэхээс татгалзах, эсхүл буцаах, хэрэгжүүлэх боломжтой гэж үзэх, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзсэн дүгнэлтийг аль нэгийг гаргадаг.

Хуулиар хориглосон, хязгаарласан газарт төсөл хэрэгжүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд хууль зүйн үндэслэлийг дурдан шууд татгалзаж шийдвэрлэдэг. Харин буцаах хариуг хүргүүлсэн тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч буцаах шалтгаан болсон асуудлуудыг засаж залруулах, бичиг баримтын бүрдлийг хангаж, дахин хянаж шийдвэрлүүлдэг. Хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд төслийг хэрэгжүүлэхээс татгалзах эсхүл буцаах дүгнэлт гаргасан ерөнхий үнэлгээний тоо гаргах боломжгүй байгааг БОАЖЯ-наас ирүүлсэн мэдээлэлд² дурдсан болно.

Харин байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний асуудлыг цахимжуулах ажлын хүрээнд ерөнхий үнэлгээний дүгнэлтийг e-mongolia системээр, үнэлгээний тайланг Байгаль

¹ 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжийн төлөөллөөс цахимаар авсан саналаас.


² Байгаль орчин аялал, жуулчлалын сайдын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 01/3987 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэл.

орчны нөлөөллийн нарийвчилсан мэдээллийн системээр гүйцэтгэж, тоон мэдээллийг нарийвчлан гаргаж эхэлсэн бөгөөд 2020-2021 оны бүртгэлээр 125 төслийн материалыг буцаах /нэмэлт материал ирүүлэх/, 7 төсөлд дүгнэлт гаргахаас татгалзаж шийдвэрлэсэн байна.

Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон яамны шинжээчид байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгүйгээр тодорхой нөхцөл болзолтойгоор 2,038 төслийг хэрэгжүүлэх боломжтой гэсэн ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргасан байна.

Ерөнхий үнэлгээний дүгнэлтэд үндэслэн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэж, тус яамаар батлуулсан болон нарийвчилсан үнэлгээ хийгдэж байгаа 6,815 төсөл байна.³

Зураг 2. Батлагдсан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тоо /2013 оноос хойш/



Эх сурвалж: <https://www.eic.mn/eia/> Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан

Ерөнхий үнэлгээг 14 хоногт багтаан хийх зохицуулалт практикт хэрэгждэггүй, ерөнхий үнэлгээний дүгнэлт, нарийвчилсан үнэлгээ, тусгай зөвшөөрөл зэрэг хуулиар тусгайлан хугацаа заасан ажлууд тухайн цаг хугацаандаа хийддэггүй, улмаар эрх бүхий аж ахуйн нэгжүүд тендерт оролцох боломжгүй болох, захиалгат ажлуудаа цуцлуулах гэх мэтээр хэвийн үйл ажиллагаа доголдох, үнэлгээний компани, төсөл хэрэгжүүлэгчийн хооронд үл ойлголцол үүсэх, санхүү, эдийн засгийн хувьд хохирох зэрэг асуудлууд их гардаг байна.

БОАЖЯ нь 6 шинжээч, 1 ерөнхий шинжээчийн хүний нөөцтэйгээр ажилладаг бөгөөд нөлөөллийн үнэлгээ хийх том, жижиг бүх төслүүдэд эдгээр шинжээчид ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргах болон нарийвчилсан үнэлгээний тайланд шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэдэг бөгөөд нэг хүнд ногдох ажлын ачаалал их байдгаас шалтгаалан хуульд заасан хугацаанд багтан дүгнэлт гаргаж амжихгүй байх улмаар үнэлгээний тайлангийн чанар алдагдах эрсдэл учирдаг байна.

Цаашид хуулийн энэхүү хугацаа заасан зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн оновчтой байдлаар өөрчилж, хүний нөөцийн чадавх болон бодит байдалд нийцүүлэн уян хатан байдлаар өөрчлөх нь үнэлгээний тайлангийн чанар, улмаар байгаль орчныг хамгаалах хариуцлагыг дээшлүүлэх үр дүнтэй болно.

³ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 01/3987 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэл. /Энэхүү тоо яамны архиваас алыан ёсоор гаргаж өгсөн тоон мэдээлэл бөгөөд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан <https://www.eic.mn/eia/> дээр гарсан тоон мэдээллээс зөрүүтэй болно./

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор баталсан журмыг удирдлага болгон Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 117 дугаар тогтоолоор баталсан ерөнхий аргачлалын дагуу тайлан хэлбэрээр боловсруулдаг. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, журамд үнэлгээний тайланд хөндлөнгийн хяналт тавих талаар тусгайлсан зохицуулалт байхгүй бөгөөд төрийн захиргааны төв байгууллагаас тухай бүр зохион байгуулдаг байна. Энэ дагуу Оюутолгой төслийн болон Дорноговь аймгийн нутагт хэрэгжиж байгаа дэд бүтцийн зарим төслүүдийн байгаль орчныг хамгаалах ажилд хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргуулахаар ажлын даалгаврыг боловсруулсан байна.

Харин байгаль орчны нарийвчилсан үнэлгээний салшгүй хэсэг болох байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих тухай зохицуулалт нь БОАЖС-ын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу хэрэгжиж байна.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх төслүүдэд тавигдах шаардлагыг том, жижиг бүх төслүүдэд ижил түвшинд тавьсан нь бодит амьдралд хэрэгжих бололцоо муу, үнэлгээ хийхэд хүндрэл учруулах, ач холбогдол багатай баримт бичгүүдээр төсөл хэрэгжүүлэгчдэд чирэгдэл болсон, дарамт учруулах нэг нөхцөл болдог байна. Иймд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх төсөл, хөтөлбөрүүдэд тавих шаардлагыг цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аж ахуйн нэгжид хүнд суртал, чирэгдэл багатайгаар шийдвэрлэх хуулийн зохицуулалт шаардлагатай байна.

Түүнчлэн БОНБҮТ хуулийн 11 дүгээр зүйлд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулж байгаа болон учруулсан бол үнэлгээний үнэн зөв хийгдсэн эсэхэд хянан магадалгаа хийхээр заасан. Энэ дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд хянан магадалгаа хийсэн болон үнэлгээг буруу хийснээс шалтгаалан учирсан хохирлын талаар тус яаманд хандсан мэдээлэл бүртгэгдээгүй байна.

Хуулинд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хугацааны талаар тодорхой зохицуулалт байхгүйгээс үнэлгээг ямар хугацаанд хүчинтэй гэж үзэх, ямар хугацааны дараа дахин үнэлгээ хийх талаарх зохицуулсан харилцаа байхгүй байна. Харин Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 5.12-т “Тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгааны үр дүнг үндэслэн боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь 5 жилээс дээшгүй хугацаатай байх бөгөөд түүнээс олон жил үргэлжлэх төслийн хувьд менежментийн төлөвлөгөөг 5 жил тутамд шинэчлэн боловсруулж батлуулна.” гэж заасны дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хугацааг 5 жил тутам шинэчлэн хийдгээс гадна төслийн хүчин чадал өөрчлөгдсөн тохиолдолд шинэчлэн хийх зохицуулалттай.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх хугацаа, давтамжийг хуульд тодорхойлон зааж өгснөөр хуулийн хийдлийг арилгах, хуулийг нэг мөр ойлгох, ойлголтын зөрүүг арилгах, тухайн харилцааг зохицуулсан журмыг хуульд нийцүүлэх зэрэг нь хуулийг хэрэгжүүлэхэд үүсэж буй хүндрэлийг багасгах юм.

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгах асуудлыг заасан бөгөөд 8.4.8-д “төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл”-ийг

үнэлгээний тайланд тусгахыг хуульчилсан. Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т “төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна” гэж заасны дагуу тухайн төслийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгуулдаг.

БОНБҮТ хууль хэрэгжиж эхэлснээс хойш баг, хорооны Иргэдийн нийтийн Хурлын саналыг тусгаагүй нарийвчилсан үнэлгээний тайлан байхгүй болно. Харин тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжих төслийн хувьд төсөл хэрэгжих газрын Хамгаалалтын захиргааны саналыг авдаг боловч хуулийн хэрэгжилтэд өртөж байгаа иргэдэд ойлголтын зөрүү, ашиг сонирхлын зөрчилтэй байдлаас шалтгаалан дээрх зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл гардаг байна. Тухайлбал, үнэлгээний тайланд зөвхөн нутгийн иргэдийн саналыг тусгахаар зохицуулсан хэдий ч иргэд тухайн төсөл хэрэгжих эсэхэд бид л зөвшөөрөл олгох эрхтэй гэж хуулийн заалтыг мушгин ойлгох, санаатай болон санамсаргүйгээр үл ойлгох, эдийн засаг болон бусад сонирхлын зөрчилтэй этгээдийн өдөөн хатгалгад автагдан үл ойлголцол үүсгэх, өөрсдийн хувийн ашиг сонирхлыг тулган гүйцэлдүүлэх хэрэгсэл болгон ашиглах, байгаль орчны нарийвчилсан үнэлгээг гацаах замаар төслийн үйл явцад саад учруулах, удаашруулах, гацаах явдал түгээмэл гардаг байна.

Хариуцлагагүй уул уурхайг хязгаарлах, нутгийн иргэдийн нийтлэг эрх ашгийг хангуулахад чиглэсэн дээрх заалт нь нөгөө талаас төсөл хэрэгжүүлэгч хийгээд үнэлгээ эрхлэгч нарт хуулийг хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгодог төдийгүй нутгийн иргэдийн зүгээс тавьж буй санал бүрийг төсөл хэрэгжүүлэгч хүлээн авах боломжгүй бөгөөд уг заалт нь бодит амьдралд хэрэгжихэд үр дүн багатай, оновчтой зохицуулалт болоогүй гэж үнэлгээ эрхлэгч нарын зүгээс илэрхийлж байсан.⁴

Мөн хуулийн нэр томъёоны тодорхойлолт хэсэгт төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд гэдгийг тодорхойлоогүй орхисноос нийтийг хамарсан тодорхойгүй нөхцөл байдал үүсдэг байна. Тиймээс хуульд төслийн нөлөөлөлд өртөх иргэдийг нарийвчлан тодорхойлох, хүрээ хязгаарыг тогтоох нь хуулийг хэрэгжүүлэх хүрээнд олон нийтийн оролцоотой холбоотойгоор үүсдэг хүндрэл бэрхшээлийг багасгах боломжийг бий болгох юм. Тухайлбал, олон сум, багийн нутаг дэвсгэрийг хамарсан төмөр зам, авто зам зэрэг шугаман байгууламж бүхий төслийн хувьд баг болгоны ИТХ-ын саналыг авах нь цаг алдах, эдийн засгийн ач холбогдол бүхий том төсөл гацах нөхцөл болсоор байна. Иймд хуулийн нэр томъёоны тодорхойлолт хэсэгт багийн иргэдийн төлөөлөгчдийн саналыг өгөх болон төслийн нөлөөлөлд өртөх иргэдийг тодорхойлох шаардлагатай байна.

Нөлөөллийн үнэлгээ хийсэн эсэхэд тавих хяналт: БОНБҮТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсэгт “Төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нөлөөллийн үнэлгээ хийсэн эсэхэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.” гэж заасан. Энэхүү зохицуулалтын дагуу нөлөөллийн үнэлгээ хийсэн эсэхэд Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий улсын байцаагч, байгаль хамгаалагч, бүх шатны засаг дарга болон хуулиар тусгайлан эрх олгосон байгууллага, албан тушаалтан хяналт тавих эрхтэй.

⁴ 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр үнэлгээ хийх эрх бүхий аж ахуй нэгжийн төлөөлөл, 01 дүгээр сарын 25-ны өдөр Байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн холбооны удирдлагатай хийсэн уулзалт, ярилцлагын үеэр гарсан саналаас.

Мөн БОАЖСайд, аймаг, нийслэлийн Засаг даргатай жил бүр байгуулдаг гэрээнд тухайн орон нутагт хэрэгжиж буй бүх төрлийн төслийг хуульд заасны дагуу үнэлгээнд хамруулах асуудлыг тусган хэрэгжилтийг ханган ажилладаг.

МХЕГ-аас чиг үүргийн дагуу тухайн жилд төлөвлөгдсөн объектуудад байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэсэн эсэхэд хяналт шалгалтыг дараах байдлаар хийдэг. Үүнд:

- Төлөвлөгөөт хяналт шалгалт;
- Төлөвлөгөөт бус хяналт шалгалт;
- Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт;
- Зөвлөн туслах.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийсэн эсэх талаар мэргэжлийн байгууллагын зүгээс тавьдаг хяналт шалгалтаар дараах төрлийн зөрчил дийлэнх нь гардаг байна. Үүнд:

- Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төрийн захиргааны төв байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын буруугаас хуулийн хугацаанд батлагддаггүй, улирлын чанартай хийгдэх ажлууд нь цаг хугацаандаа хийгдээгүйгээс шинжилгээний хариу буруу үр дүн үзүүлэх, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж нь хээрийн судалгааны анхдагч материал, үнэлгээний мэргэжилтний судалгааны ажлын дүн газар дээрээ нийцэхгүй байх зэрэг зөрчил илэрдэг.
- Мөн уул уурхайн болон аялал жуулчлалын зарим аж ахуйн нэгжүүд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагаар батлуулах ажил хийгдэхгүй байх, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ удаан хугацаанд хийгдэх, дээрх 2 баримт бичгийг холбогдох газарт өгсөн хэдий ч баталж өгөхгүй шалтгаанаар төлөвлөгөөний баталгаажуулалт хийгдэхгүй байх тохиолдол гардаг байна. Үйлдвэрийн бүсийн газар олголтын хэмжээ бага байгаатай холбогдож, жижиг, дунд үйлдвэрүүдийг үнэлгээний шаардлага хангасан байрлалд үйл ажиллагаа явуулахыг МХЕГ-аас шаардахад хүндрэл учирдаг байна.
- Түүнчлэн хуулийн хэрэгжилтийг тогтмол шалгах боломж төсвийн байгууллагын зардлаас хамаараад хомс байдаг ба нэг удаагийн явалтаар олон ажлын гүйцэтгэлийг үзэж ирэх шаардлагатай болдог нь ажлын чанар, үр дүнд сөргөөр нөлөөлдөг байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө: Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт *“Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага боловсруулна.”* гэж заасан.

Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч, дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг баталдаг.

Алт, зэс, нүүрсний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн менежментийн төлөвлөгөөг хянасан байдлыг сүүлийн 3 жилээр байдлаар авч үзвэл 2018 онд 114, 2019 онд 215, 2020 онд 140 менежментийн төлөвлөгөөг тус тус хүлээн авч хянасан

байна. Харин 2013-2018 оны мэдээллүүд цахимаар байхгүй бөгөөд цахимжуулах ажлыг салбарын яам гүйцэтгэж байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллаагүй тохиолдолд оногдуулах мөнгөн торгуулийн хэмжээ 2013-2017 хооронд 3,000,000 төгрөг байсан бол 2017 оноос 500,000 төгрөг болж буурсан. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан зөрчилд оногдуулах хариуцлагын хэмжээ 500,000 төгрөг байгаа нь төсөл хэрэгжүүлэгчдэд эдийн засгийн хувьд цочроо өгч чадахгүй байгаа төдийгүй, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой менежментийн төлөвлөгөөний ач холбогдол буурах улмаар тус харилцааг зохицуулсан хуулийн зүйл, заалт хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна. МХЕГ-аас цахимаар ирүүлсэн мэдээллээр 2013-2020 оны хооронд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон Зөрчлийн тухай хуулиар нийт 768 зөрчилд 515,650,000 төгрөгийн торгууль шийтгэл ногдуулсан байна.

БОАЖЯ-аас ерөнхий үнэлгээ хийсэн бүх төслүүдийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа нь аж ахуйн нэгж, төсөл хэрэгжүүлэгч нарт чирэгдэл учруулдаг тул тиймээс менежментийн төлөвлөгөөг батлах, хянах, тайлагнах зэрэг үйл ажиллагааг тухайн төслийн онцлогоос нь хамааруулаад орон нутагт /аймаг, нийслэл, сумд/ өгөх нь цаг хугацаа хэмнэх, менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээллийг орон нутгаас авах боломжтой гэж Мэргэшсэн үнэлгээчдийн холбоо үзэж байна.

Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.12-т *“Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина”* гэж заасан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д зааснаар тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс газар дээр нь очиж үнэлж дүгнэдэг. Хэрэгжилтийн явцад нь хяналт тавих чиг үүргийг төрийн хянан шалгах чиг үүргийг Мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлдэг бөгөөд Монгол Улсын хэмжээнд албан ёсоор уул уурхайн хаалт хийгдээгүй байна.

МХЕГ-аас 2017-2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 547 объектод байгаль орчны хяналт шалгалтыг хийж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийг шалгахад 502 аж ахуйн нэгж буюу 91.6% нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.

Харин байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас УИХ, Засгийн газрын бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн захиргааны байгууллага, иргэдийн гомдол мэдээллийн дагуу хяналт, шалгалтын арга хэмжээг тухай бүрд зохион байгуулж үр дүнгийн мэдээллийг холбогдох байгууллага, олон нийтэд хүргэдэг байна. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын шийдвэрээр хөндлөнгийн хяналтын талаарх нарийвчилсан тоо мэдээлэл байхгүй байна.

Тухайн жилийн аж ахуйн нэгжүүдийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг үнэлж, дүгнэсэн баримт бичгийг үндэслэн дараа жилийн төлөвлөгөөг батлахаар журамласан ч уг журмын дагуу Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлангаа орон нутгийн ажлын

хэсгээр дүгнүүлээгүй аж ахуйн нэгжүүдийн дараа оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-аар батлуулсан тохиолдол гарсан байна. Энэ нь эрх бүхий төрийн захиргааны байгууллага хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, эрх мэдлээ хэтрүүлэх, бусдад давуу байдал бий болгож байгааг харуулж байна.

Менежментийн төлөвлөгөөний биелэлт хэрэгжилтэд тавих орон нутгийн хяналт төдийлөн хэрэгждэггүй, Мэргэжлийн хяналтын байгууллагаас хийгддэг хяналт шалгалтад жилд 2 удаа хамрагддаг байна. Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2013-2020 онуудад хяналт шалгалтаар 2,487 орчим зөрчил дутагдал илрүүлж, тухай бүрд нь хугацаатай албан шаардлага, зөвлөмж, актын биелэлтээр зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахдаа аж ахуйн нэгж бүрд адил загвар шалгуураар ханддаггүй, төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх хугацааг тодорхой зааж өгдөггүй, “жилдээ” гэсэн хугацаа тавьдаг, мөн зарим төлөвлөгөөнд хүснэгт нь зөрүүтэй, зарим ажил нэг аж ахуйн нэгжид төлөвлөгдсөн ч нөгөө аж ахуйн нэгжид төлөвлөгдөөгүй байдлаар баталдаг зэргээс шалтгаалан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар явах үед хяналт тавих, биелэлтийг тооцоход хүндрэл үүсгэдэг байна.

Батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилладаггүй, хийсэн тайлангаа дарчихдаг тохиолдол түгээмэл байдаг учраас хяналт шалгалтыг тогтмол хийх замаар менежментийн төлөвлөгөөний ач холбогдол, үр дүнг сайжруулах боломжтой юм.

Нөхөн сэргээлтийн тусгай данс: Төсөл хэрэгжүүлэгчийн нөлөөллийн үнэлгээгээр тавигдсан шаардлага болон уурхайн ашиглалтын жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу уурхайн хаалтын үе шатанд буцаан олгодог зохицуулалттай. БОАЖЯ-аас авсан мэдээллээр⁵ 2013-2020 онуудад 2 аж ахуйн нэгж байгууллагад 145.1 сая төгрөгийн баталгааны мөнгөн хөрөнгийг буцаан олгосон байна.

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгаль орчны нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийн хэмжээг бага байлгах сонирхолтой, уг барьцаа хөрөнгийг бага байршуулдгаас шалтгаалан байгаль орчны нөхөн сэргээлт хийгддэггүй, аж ахуйн нэгж байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх нэг нөхцөл болдог гэдгийг байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын төлөөлөл илэрхийлж байсан.

Шүүхийн практик ч байгаль орчны нөхөн сэргээлттэй холбоотой гомдлын тоо тасрахгүй байгаа нь байгаль орчны нөхөн сэргээлт бодит утгаараа хийгдэхгүй, хуулийн 9.9, 9.10-т нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулж байгаа мөнгөн хөрөнгөтэй холбоотой зохицуулалт нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоо хангаж чадахгүй байгааг харуулж байна.


⁵ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 01/3987 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэл.

Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан болон холбогдох хяналтын дүнг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчийн баталгааны мөнгийг буцаан олгох эсэх асуудлыг шийдвэрлэдэг.

Гэтэл төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүд энэхүү тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгөө буцааж авахад хүндрэлтэй байдаг ба энэхүү нөхөн сэргээлтийн дансанд байшуулсан мөнгөн хөрөнгийг байгаль орчныг нөхөн сэргээхэд чиглэсэн оновчтой зохицуулалт болж чадахгүй байна гэж үздэг. Тухайлбал, уул уурхайн салбарт энэхүү байгаль орчны нөхөн сэргээлтэд зарцуулагдах барьцаа хөрөнгө зайлшгүй шаардлагатай бол эдийн засгийн бусад салбар болох цахилгаан станц, хөдөө аж ахуй, жуулчны бааз зэрэгт төдийлөн тохиромжгүй ба аж ахуйн нэгж байгууллага өөрсдөө хуримтлал үүсгээд хөрөнгийн зах зээлд өсгөөд төслийн хаалтын гэрээний үед ашиглах нь илүү оновчтой юм гэсэн байр суурь ч гарч байсан. 2015 оны байдлаар Монгол орны нийт уурхайн үйл ажиллагаанд өртсөн газарт хийх нөхөн сэргээлтийн биелэлт 20 гаруй хувьтай байна.⁶

Байгаль хамгаалалтын тусгай дансанд 2019 онд 2,317 сая төгрөг төвлөрсөн ба буцаан олголт байхгүй гэж БОАЖЯ тайлагнажээ. Тус дансны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн эцсийн үлдэгдэл нь 16,354 сая төгрөг байна.⁷

Зураг 3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрсөн төлбөр /сая төгрөг/



Эх сурвалж: <https://www.eitimongolia.mn/p/80>

Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10-д Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэхээр зохицуулсан.

⁶ “Хариуцлагатай уул уурхай” сургалтын гарын авлага, Иргэний шийдэл бодлогын судалгааны төв, НҮБХХ

⁷ Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга., <https://www.eitimongolia.mn/p/80>

БОАЖЯ-ны Төрийн сангийн тусгай дансанд 2006-2020 оны хооронд нийт 1,135 аж ахуйн нэгж, байгууллагуудаас 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 17.9 тэрбум төгрөг төвлөрсөн байна.⁸

Дээрх дансанд байршуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 2020 онд Цэнхэр сумын Орхон багийн нутагт байрлах “Эм жи эйч” ХХК-ийн эзэмшиж байсан тусгай зөвшөөрлийн талбайд нөхөн сэргээлтийг хийгээгүй учраас тус компанийн яамны тусгай дансанд төвлөрүүлсэн 84 сая төгрөгөөр эвдрэлд орсон 10 га талбайн техникийн нөхөн сэргээлт хийлгэх зорилгоор Архангай аймгийн ЗДТГ, БОАЖГ-аас гүйцэтгэгч компанийг шалгаруулж, нөхөн сэргээлтийг хийлгүүлсэн нь анх удаа яамны тусгай дансанд байршуулсан хөрөнгөөр нөхөн сэргээлт хийлгэсэн тохиолдол болсон байна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шинжилгээ: Хуулийн 10 дугаар зүйлд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний ажлыг холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэсэн эсэх, тайлан, дүгнэлт үндэслэлтэй, зөв эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах ажиллагаа болох үнэлгээний шинжилгээний талаарх зохицуулалтыг тусгасан.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын шинжээчид хүргүүлэх ба тайланг хүлээн авсан шинжээч ажлын 18 өдөрт багтаан үнэлгээний шинжилгээ хийж, дүгнэлт гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ерөнхий шинжээч уг тайланд үнэлгээний шинжилгээ хийх шинжээчдийн багийг томилдог. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүнд үнэлгээ хийсэн шинжээчийн болон Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдын саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэдэг.

Энэхүү үнэлгээний шинжилгээ хийхтэй холбоотой практикт түгээмэл гардаг асуудал бол үнэлгээний шинжээчийн чадвар, туршлагын асуудал байдаг. Төрийн бодлогын залгамж чанар муу, салбарын сайд солигдох бүрт төрийн албан хаагчдыг халж сольдог учраас яамны мэргэжилтнээр мэргэжлийн бус хүнийг томилох, тухайн асуудлаар мэргэших боломж хомс, нарийн мэргэжлийн шинжлэх ухааны судалгаа, тайланг уншаад мэргэжлийн шүүмж өгөх чадвар хомс байдаг гэдгийг үнэлгээ эрхлэгчдийн зүгээс илэрхийлж байсан. Тайлангаа батлуулж, ажлаа эхлэхийн тулд яамны мэргэжилтний тавьсан мэргэжлийн бус шаардлагыг хүлээн зөвшөөрч тайлангаа батлуулах болдог төдийгүй зарим тохиолдолд шүүмжээ бичүүлж авах шинжээч ч байдаг байна.

Мөн хуульд заасан тайланг хянах хугацаа бодит амьдрал дээр хэрэгждэггүй, хуульд заасан хугацаа хэтрэх тохиолдол байнга гардаг. Иймд хуулийн энэ заалтын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр салбарын яам санаачилгатай ажиллах, зохион байгуулалтын оновчтой хэлбэрийг нэвтрүүлэх, эсхүл хуульд заасан хугацааг эргэн харж, бодит байдалтай нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

Хянан магадалгаа: Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны улмаас

⁸ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 01/3987 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэл.

хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулж байгаа болон учруулсан бол үнэлгээний үнэн зөв хийгдсэн эсэхэд хянан магадалгаа хийдэг.

БОАЖЯ-аас ирүүлсэн мэдээлэлд⁹ хууль батлагдсанаас хойш буюу 2012 оноос хойш хянан магадалгаа хийгдээгүй байна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлантай яамны шинжээч танилцаад гаргасан шүүмжийн дагуу засвар хийгээд, дахин мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж баталдаг. Өөрөөр хэлбэл яам хангалттай хянаж, хэлэлцэж баталчихаад дахин хянан магадалгаа хийх нь ач холбогдолгүй гэдгийг үнэлгээ эрхлэгчдийн төлөөлөл илэрхийлж байсан.

Хуулийн 11.5 дахь хэсэгт “Хянан магадалгаагаар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн нь тогтоогдвол уг ажлыг зохих шаардлагын түвшинд хүртэл дахин хийлгэж, энэ хугацаанд бусад төсөлд нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр түдгэлзүүлнэ” гэж заасан. Үнэлгээний хянан магадалгаа хийгдээгүй учраас нарийвчилсан үнэлгээг буруу хийснээс үнэлгээ хийх эрхийг нь түдгэлзүүлсэн тохиолдол гараагүй хэдий ч 39 компаний үнэлгээ хийх эрхийг чадавхийн үнэлгээ хийх шалгалтад тэнцээгүй шалтгаанаар түдгэлзүүлсэн байна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн чанар муу, мэргэжлийн байгууллагын чадавх сул талаар гомдол, санал гарах болсонтой холбогдуулан мэргэжлийн байгууллагын чадавхыг үнэлж, аттестатчилал явуулах шаардлагатай гэж үзэн БОАЖС-ын 2018 оны А/56 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан урьдчилсан судалгаанд дүн шинжилгээ хийх, мэргэжлийн байгууллагыг үнэлэх үнэлгээний хуудсыг боловсруулж, 184 мэргэжлийн байгууллагад чадавхын үнэлгээ хийж, үр дүнг сайдын зөвлөлийн хуралд танилцуулсан.

Мөн 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/200 дугаар тушаалаар үнэлгээний компаниудын дунд чадавхын үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулан ажлын удирдамжийг баталж, үнэлгээний компаниудад мэдэгдэл хүргүүлэн ажилласан байна.

Зураг 4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн байгууллагуудын чадавхыг үнэлсэн байдал /2018 он/¹⁰

Шаардлага хангасан	Зөрчлийг арилгах боломжтой	Шаардлага хангаагүй	Үйл ажиллагаа явуулдаггүй	Дүгнүүлээгүй
60	75	6	4	24

Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх эрх олгох, хүчингүй болгох: Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийг Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан шаардлагыг хангасан Монгол Улсын аж ахуйн нэгжид олгохдоо өргөдөл гаргасан аж ахуйн нэгжийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх чадварыг Мэргэжлийн зөвлөл ажлын 28 өдөрт багтаан шалгаж, дүгнэлт гаргадаг.

⁹ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 01/3987 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэл.

¹⁰ Байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018 он

Ажлын 28 өдөрт багтаан үнэлгээ хийх эрх олгох зохицуулалт хэрэгждэггүй, эрх шинээр авах болон сунгуулах хүсэлтээ өгснөөс хойш хуульд заасан дээрх хугацаанд шийдвэр гаргадаггүйн улмаас аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх, тендэрт оролцох боломжгүй болох, захиалгат ажлуудаа цуцлуулах гэх мэтээр санхүүгийн болоод бусад хэлбэрээр хохирдог явдал түгээмэл байна.

Тохиолдол судлал:

Манай компани тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлтээ 2021 оны 02 дугаар сард яаманд өгөөд 10 сарын сүүлээр эрхээ сунгуулсан.

/Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний компаний төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас.../

2021 оны байдлаар яамнаас БОНБҮТ хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу нийт 344 байгууллагад Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх олгосон байна. Эдгээрээс зарим хуулийн этгээдийн эрхийн хугацаа дуусгавар болсныг сунгуулаагүй, өөр үйл ажиллагаа эрхлэх, чадавхын үнэлгээ хийх шалгалтад хамрагдаагүй, үнэлгээг хангалтгүй гүйцэтгэсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй зэргээс шалтгаалан эрхийн хугацааг сунгахгүй байх, цуцлах шийдвэрийг гарган ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 180 гаруй мэргэжлийн байгууллагын эрх хүчин төгөлдөр байна.

Тус хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт аж ахуйн нэгжид байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр гурван жилийн хугацаатай олгоно гэж заасан нь үнэлгээ эрхлэгч нарт хүндрэл чигрэгдэл учруулах, хүнд суртал бий болох нэг шалтгаан болж байна гэдгийг үнэлгээ эрхлэгч нар илэрхийлж байсан.

Хийсэн үнэлгээний ажил нь төрийн байгууллагаар тухай бүр хянагдаад явдаг учраас үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жил болгож сунгах нь төрийн үйл ажиллагааг иргэд, аж ахуйн нэгжид хүндрэл чирэгдэл багатай, хурдан шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

Үнэлгээ хийх эрхтэй аж ахуйн нэгжийг чадавхжуулах, үнэлгээний үр дүн, ач холбогдлыг нэмэгдүүлэхэд дан ганц үнэлгээ эрхлэгчдийг аттестатчлахаас гадна байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг шинээр олгохдоо тавигдах шалгуурыг өндөр тавих шаардлагатай байна. Тухайлбал, салбартаа 5-аас доошгүй жил ажилласан, үнэлгээний ажлын дадлага туршлагатай байх гэх мэт шалгуурыг тавьж өгснөөр чанаргүй олон үнэлгээний компаниуд бий болох, үнэлгээний ажлын чанар муудах зэрэг эрсдэлээс сэргийлэхээс гадна үнэлгээний компаниуд чадавхижих, улмаар үнэлгээний тайлан, үр дүн бодитой болох, хуулийн хэрэгжилт хангагдах нэг нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэгт “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийхэд үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлнэ” гэж заасан. Энэ нь бодит байдалд төдийлөн хэрэгждэггүй, зураг төслийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, ТЭЗҮ хийдэг аж ахуйн нэгж гэх мэт үндсэн үйл ажиллагаа нь үнэлгээ хийхэд чиглэгдээгүй аж ахуйн нэгжүүд хавсарга байдлаар үнэлгээ хийж байгаа нь үнэлгээний компанийн чадавх хийгээд үнэлгээний тайлангийн чанар, үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 9.11-д “Мэргэжлийн зөвлөлийн гишүүн нь ашиг сонирхлын зөрчилгүй байх ба холбогдох хуулийн дагуу энэ асуудлаар мэдэгдэл гаргаж өгнө” гэж ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохицуулалт хийсэн хэдий ч бодит байдалд хэрэгжилт хангалтгүй байгааг хуулийн үнэлгээ эрхлэгчдийн төлөөлөл хэлж байсан.¹¹

Үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хийсэн уулзалтын үеэр үнэлгээний эрх олгох, сунгах, түүнчлэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гаргаж, төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх зэрэгт яамны мэргэжилтнүүд ашиг сонирхлын зөрчилтэй байр сууринаас хандах, өөрийн хамаарал бүхий аж ахуйн нэгжээр төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэх сонирхолтой байх, ашиг сонирхлын болон бусад шалтгаанаар үнэлгээг баталж өгөхгүй удаах, цаг алдуулах зэргээр аж ахуйн нэгжүүдэд хүндрэл үүсгэх тохиолдол гардгийг хэлж байсан.

Албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхолдоо хөтлөгдсөн энэхүү үйлдлийн улмаас төсөл хэрэгжүүлэгчдийн зүгээс үнэлгээ хийлгэх аж ахуйн нэгжийг сонгохдоо тэдгээрийн ажлын туршлага, чадварыг харгалзахаас илүүтэйгээр яаманд танил талтай эсэх, үнэлгээг хир хурдан хугацаанд батлуулан гаргуулж өгөх вэ гэдгийг харгалздаг үнэлгээ хийлгэх жишиг тогтсон байна.

2.3. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд оролцогчдын эрх, үүргийн хэрэгжилт:

Хуулийн 3 дугаар бүлэгт байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлсон. Ийнхүү тодорхойлохдоо үнэлгээнд оролцогч төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн болон үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжийн эрх, үүргийг нарийвчлан тодорхойлохоос гадна банк, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын байгууллагын эрх, үүргийг зохицуулсан. Харин төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүргийг нарийвчлан тодорхойлоогүй байна.

Стратегийн үнэлгээнд хамрагдах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулсан байгууллага болон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүргийг хуульд тодорхойлохдоо газрын тос болон уул уурхайн төслүүд нь нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөөг тухайн үйл ажиллагаа эхэлж, хаалт хийхээс гурван жилээс доошгүй хугацааны өмнө боловсруулж, тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэхийг заасан.

Уурхайн хаалтын асуудал нь өөрөө байгаль орчны асуудлаас гадна орон нутгийн нийгэм, эдийн засгийн асуудлыг хамарсан ТЭЗҮ, БОННУ зэрэгт тулгуурласан хаалтын төлөвлөгөө байх ёстой. Гэтэл 3 жилийн өмнө хаалтын төлөвлөгөө хийх нь хуримтлал үүсгэх хангалттай хугацаа биш бөгөөд богино хугацаанд хуримтлал үүсгээгүй уурхай хаалт хийх бүрэн чадваргүй байдаг байна.

Иймд хаалтын менежментийн төлөвлөгөөг хаалт хийхээс гурван жилээс доошгүйн өмнө хийж, холбогдох байгууллагаар батлуулах гэсэн заалт нь эко тогтолцооны үйл ажиллагаа болон газар хөрсний үржил шимийг хуучин хэвэнд нь буцаан оруулах зорилготой байгаль орчны нөхөн сэргээлт хийгдэх боломжийг хаасан зохицуулалт болсон байна.

¹¹ 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр үнэлгээ хийх эрх бүхий аж ахуй нэгжийн төлөөлөл, 01 дүгээр сарын 25-ны өдөр Байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн холбооны удирдлагатай хийсэн уулзалт, ярилцлагын үеэр гарсан саналаас.

2.4. Нөлөөллийн үнэлгээний үйл ажиллагааны олон нийтийн оролцоо:

2012 оны БОНБҮТ хуульд оруулсан зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг батлахаас өмнө орон нутгийн байгууллага, нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, олон нийтэд танилцуулах, зөвлөлдөх, улмаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх заалтуудыг оруулж, олон нийтийн оролцооны асуудлыг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар нарийвчлан зохицуулахаар тусгасан юм.

Дээрх зохицуулалтын дагуу “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”-ыг салбарын сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-03 дугаар тушаалаар баталж, байгаль орчны стратегийн үнэлгээ, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний явцад олон нийтийн оролцоог хэрхэн хангах талаар тусгайлан журамласан. Гэвч хуулийг хэрэгжүүлэх явцад тулгарч байгаа хүндрэл, бэрхшээл, үүсэж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг судлах явцад төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчид болон үнэлгээ эрхлэгчдэд хүндрэл учруулж, асуудал үүсгэх болсон зохицуулалт нь “Олон нийтийн оролцоо”-г хангах асуудал болоод байна.

Олон нийтийн оролцоо нь төслийн сөрөг нөлөөллийг оновчтой, бүрэн гүйцэт тодорхойлох, сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах арга замуудыг тодорхойлох, улмаар байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг зөв төлөвлөх, иргэд төслийн эерэг, сөрөг нөлөөллийн талаар мэдээлэл авах боломжийг олгох, түүнчлэн түүнд түшиглэн хяналт тавих боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой тул оролцоог үр дүнтэйгээр хангах нь чухал.

БОНБҮ-нд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа нь хуульд заасны дагуу БОАЖЯ-аас шаарддаг үнэлгээний тайланг хэлэлцсэн талаарх ИНХ-ын тогтоол, тэмдэглэлийг гаргуулан авахад анхаарлаа хандуулж, харин хууль, журамд заасан иргэдийг мэдээллээр хангах, тэднээс урьдчилан санал авах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, тайлангийн ил тод байдлыг хангах талын хэрэгжилт төдийлөн хангалттай бус байна.

БОАЖЯ-наас БОНБҮТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8-д заасны дагуу “*төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн Нийтийн хурлын санал, тэмдэглэл*”-ийг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгах”, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 4-т “*төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна*” гэж заасны дагуу тухайн төслийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгуулан ажиллаж байна.

Яамнаас хуулийн хэрэгжилтийн талаар ирүүлсэн мэдээлэлд¹² дурдсанаар баг, хорооны иргэдийн нийтийн Хурлын саналыг тусгаагүй нарийвчилсан үнэлгээний тайлан байхгүй, харин тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжих төслийн хувьд төсөл хэрэгжих газрын Хамгаалалтын захиргаанаас саналыг авдаг байна.

Хуулийн 8.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог заавал иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлсэн тогтоол, шийдвэрийг албажуулан хавсаргах нь үнэлгээ эрхлэгчдийн хувьд хамгийн хүндрэлтэй асуудал болдог байна. Түүнчлэн, үнэлгээ эрхлэгч,

¹² Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 01/3987 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэл.

төсөл хэрэгжүүлэгчид үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах гол арга зам болж буй ИНХ-аар тайланг хэлэлцүүлэх ажлын зорилгын талаар ойлголтын зөрүүтэй байгаа нь хурлын зохион байгуулалт, талуудын оролцооны идэвх, сонирхолд сөргөөр нөлөөлдөг байна.

Өөрөөр хэлбэл, баг, хорооны ИНХ-аар үнэлгээний тайланг хэлэлцүүлэх нь орон нутгийн иргэдэд мэдээлэл өгөх, тэдний санаа бодлыг авах, тусгах зорилготой юу, эсвэл тэднээс дэмжиж байна гэсэн шийдвэр гаргуулах зорилготой юу гэдэг дээр оролцогч талууд өөр өөрийн талаас харилцан адилгүй байр суурьтай, ойлголтын зөрүүтэй байгаагаас үнэлгээ хийх үйл ажиллагаанд хүндрэлтэй асуудлууд үүсдэг талаар хяналт шинжилгээний хүрээнд хийсэн уулзалт, ярилцлага бүрд хөндөгдөж байсан болно.

Орон нутгийн удирдлага, иргэдийн хувьд ИНХ-ын хэлэлцүүлгийг иргэдийн дэмжсэн эсэх саналыг авах “зөвшөөрөл” өгч буй үйл явц гэсэн явцуу утгаар ойлгож ханддаг бол Яамны зүгээс иргэдийн саналыг үнэлгээний тайланг боловсруулахад хэрхэн авсан, тэдгээрийг тайланд хэрхэн тусгасанд анхаарахаас илүүтэй дэмжсэн эсэх тухай тогтоолд ач холбогдол өгдөг гэж үзэж байна¹³.

Хуульд заасан ИНХ-ын тогтоол тэмдэглэлийг үнэлгээний тайланд хавсаргах зохицуулалт хангалттай хэрэгжиж байгаа хэдий ч иргэдийн саналыг авах, хэлэлцүүлэх зохион байгуулах ажил үр дүнтэй явагдаж, байгаль орчны шийдвэр гаргахад ач холбогдолтой мэдээллийг танилцуулах, оршин суугч, нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах замаар олон нийтийн оролцоог хангаж чадаж байгаа эсэхэд орон нутгийн удирдлага, салбарын яам болон Мэргэжлийн зөвлөл төдийлөн анхаарал хандуулахгүй байна.

Хуулийн нэр томъёоны тодорхойлолтод субъектийг дутуу тодорхойлсон буюу “нөлөөлөлд өртөгч” гэж хэнийг хэлэх талаар тодорхойлоогүй хэрнээ ач холбогдол өгсөн хэд хэдэн заалтыг оруулсан учраас үнэлгээ эрхлэгчид нөлөөлөлд өртөгчдийг тодорхойлохдоо тухайн сумын ИТХ-ын хуралдаанаар оруулж хичнээн айл, өрх нөлөөлөлд өртөж байгааг тогтоож ирсэн тул хуульд нөлөөлөлд өртөгч гэдгийг тодорхойлж өгөх нь зүйтэй байна.

БОАЖЯ-наас тавьсан хүсэлтийн дагуу Австрали Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах хууль, эрх зүйн зохицуулалтыг сайжруулахад чиглэсэн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь: оролцогч талуудын судалгаа” сэдэвт оролцогч талуудын оролцоог хангасан, ач холбогдол бүхий судалгааны ажлыг 2021 онд хийсэн байна.

Уг судалгаа нь БОНБҮТ хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2014 онд батлагдсан БОНБҮ-нд олон нийтийн оролцоог хангах тухай журмыг боловсронгуй болгох ажлын хүрээнд уг журмыг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэлтэй асуудлууд, тэдгээрийн шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулах, олон нийтийн оролцоог үр дүнтэй хангах чиглэлээр оролцогч талуудын санаа бодлыг нэгтгэх зорилгоор хийгдсэн. Судалгаанд БОНБҮ хийх эрх бүхий компаниудын төлөөлөл, үнэлгээний ажлын захиалагч тал болох уул уурхай, бусад салбарын компаниудын төлөөлөл, салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл, орон нутгийн удирдлага (сум, дүүрэг, баг хорооны), иргэдийн төлөөлөл зэрэг нийт 115 оролцогчийг хамруулан зохион байгуулсан нь хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхэд үр дүнтэй судалгааны ажил болсон байна.

¹³ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь, Улаанбаатар, 2021 он, 15 дахь тал.

Судалгаанд БОНБУ-ний тогтолцоонд олон нийтийн итгэх итгэл сул байгааг онцолж, үүнд нөлөөлж байгаа гол хүчин зүйлс нь нөлөөллийн үнэлгээний дагуу байгаль хамгаалах үр дүнтэй ажлууд хийгддэггүй, үнэлгээ нь иргэдэд ойлгомжгүй, ил тод бус, санал өгсөн ч түүнийг тайланд тусгана гэдэг итгэл, хүлээлт бага байдаг гэдгийг онцолсон байна.¹⁴

Орон нутгийн удирдлагын үүрэг хариуцлагын талаар зохицуулаагүй орхигдуулснаас болж ИНХ-ын хуралдааны тов, давтамж тодорхой бус, хурлын ирцийг бүрдүүлэхэд ихээхэн хүндрэл тулгарч байна. Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 3 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцох зохицуулалт үйлчилж ирсэн.

Уг асуудал нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар зохицуулагдаж ирсэн бөгөөд хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдан өөрчлөлт орж 2022 оноос хэрэгжиж эхлээд байна.

д/д	МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ 2006 оны 12 сарын 15-ны өдөр	МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2020 оны 12 сарын 24-ний өдөр
1	23.10.Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.	32.6.Тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн болон хорооны хэсэг тус бүрийн төлөөллийг хангах зарчмаар багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд гурван өрх тутмаас, 400-аас дээш өрхтэй багт таван өрх тутмаас, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд хорооны хэсэг тус бүрийн 20 өрх тутмаас тус бүр нэгээс доошгүй хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно. Иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны товыг хуралдаан болохоос ажлын таваас доошгүй өдрийн өмнө тухайн баг, хорооны оршин суугчдад мэдээлэх бөгөөд хуралдах байршил, цагийг тусгасан байна.
2	23.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын ээлжит хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа, баг, хорооны Хурлын хуралдааныг жилд 3-аас доошгүй удаа тус тус хуралдуулна.	46.2.Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын ээлжит хуралдааныг улиралд нэг удаа хуралдуулна.
3	23.3.Төлөөлөгчдийн гуравны хоёроос доошгүйн шаардсанаар, эсхүл Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр ээлжит бус хуралдаан хуралдуулж болно.	46.4.Иргэдийн Нийтийн Хурлын ээлжит бус хуралдааныг Хурлын Зөвлөл, Засаг даргын санаачилгаар, эсхүл баг, хорооны сонгуулийн эрх бүхий иргэдийн арваас доошгүй хувь нь санал болгосноор хуралдуулна. Иргэд саналаа гарын үсэг зурах хэлбэрээр илэрхийлнэ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын ээлжит хуралдааныг жилд 2-оос доошгүй удаа, баг, хорооны Хурлын хуралдааныг жилд 3-аас доошгүй удаа хуралдуулах зохицуулалттай байсан бол 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлээд буй шинэчилсэн найруулгаар Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын ээлжит

¹⁴ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь, Улаанбаатар, 2021 он, 55 дахь тал.

хуралдааныг **улиралд нэг удаа** хуралдуулахаар өөрчлөлт орсон байна. Улиралд нэг удаа хуралдуулна гэж заасан хэдий ч хэзээ болох тов тодорхойгүй байдаг нь ихээхэн хүндрэлтэй байдаг талаар мэдээлэл цуглуулах явцад хийсэн уулзалт, ярилцлага тухай бүрд хөндөгдөж байсан.

Мөн дээрх хуулийн 32 дугаар зүйлийн 32.6.-д Тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн болон хорооны хэсэг тус бүрийн төлөөллийг хангах зарчмаар багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд **3** өрх тутмаас, 400-аас дээш өрхтэй багт **5** өрх тутмаас, хорооны иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанд хорооны хэсэг тус бүрийн **20** өрх тутмаас тус бүр нэгээс доошгүй хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцохоор шинэчлэн найруулсан нь иргэдийн оролцоог хангах тал дээр ахиц гарсан хэдий ч төсөл хэрэгжүүлэгч болон үнэлгээ эрхлэгчдийн хувьд үүсдэг хүндрэл хэвээр байна.

Олон нийтийн оролцоог хангах иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлсэн тогтоол, тэмдэглэлийг албажуулахад баг, хороодын хурлын тогтсон хуваарь буюу тов байдаггүй. Баг, хорооны удирдлага тухай бүрд нь шийдвэр гаргаж ээлжит болон ээлжит бус хуралдааныг зохион байгуулдаг бөгөөд зөвхөн үнэлгээний тайлан хэлэлцэхтэй холбоотой ээлжит бус хурал хуралдуулсан тохиолдол ховор байна.

Хөдөө, орон нутагт ихэнхдээ Цагаан сарын өмнө нэг удаа, хавар мал төллөсний дараа буюу 5, 6-р сарын үеэр нэг удаа, намар хадлан, өвлийн бэлтгэлийн дараагаар буюу 10-р сарын орчимд нэг удаа багийн хурал зохион байгуулагддаг байна. Зарим орон нутагт улирал бүр багийн хурал хуралддаг бол зарим газар хурлын тов, давтамж хэлбэлзэлтэй байдаг төдийгүй байгаль цаг уурын давагдашгүй хүчин зүйлс, орон нутгийн яаралтай ажлууд, сонгуулийн мөчлөг, хурлын ирц дутуу зэрэг шалтгаанаар товлогдсон хурал цуцлагдах тохиолдол олон гардаг байна.

Жилд дунджаар 2-4 удаа болдог ИНХ-ын хуралдааны товыг 3-6 сар хүлээх тохиолдол гардаг нь дараах сөрөг үр дагаврыг бий болгодог байна. Үүнд:

- Тухайн төслийн төлөвлөлт, явцыг удаашруулах, зогсоох, улмаар эдийн засгийн үнэ цэнэ буурдаг.
- 3-6 сарын хугацаанд хүчинтэй байдаг Ерөнхий үнэлгээний хугацаа дуусдаг тул дахин дүгнэлт гаргуулах болдог.
- Хурлыг зохион байгуулахын тулд орон нутгийн удирдлагад нөлөөлөх, тохиролцох, авлига өгөхөд хүргэдэг.
- Хуралдаан болсон мэт хуурамч бичиг баримт бүрдүүлэх зэрэг зөрчил гардаг байна.

Нөгөө талаар хурлын ирцийг бүрдүүлэх нь орон нутгийн удирдлагын эрх хэмжээний асуудал учраас төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ эрхлэгч нь орон нутгийн удирдлагатай хэрхэн хамтарч ажиллахаас ихээхэн шалтгаалдаг байна. Зарим тохиолдолд энэ нь ашиг сонирхлын зөрчил, авлигын эрсдэл ч үүсгэдэг байна¹⁵. Төсөл хэрэгжүүлэгч орон нутгийн удирдлагатай ямар харилцаатай байхаас хамаарч хурлын ирцийг бүрдүүлж, үнэлгээг хэлэлцэх эсэхийг шийддэг байдал нилээдгүй байна. Энэ харилцаа нь төсөл хэрэгжүүлэгч орон нутагт тодорхой бүтээн байгуулалт, хандив тусламжийн амлалт өгч тохиролцох, заримдаа орон нутгийн удирдлагад шан харамж өгөх эсэхээс хамаардаг байна.

БОАЖЯ-наас хуулийн хэрэгжилтийн талаар ирүүлсэн мэдээлэлд¹⁶ сайд, аймаг, нийслэлийн Засаг даргатай жил бүр байгуулдаг гэрээнд тухайн орон нутагт хэрэгжиж буй бүх

¹⁵ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь, Улаанбаатар, 2021 он.

¹⁶ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 01/3987 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэл.

төрлийн төслийг хуульд заасны дагуу үнэлгээнд хамруулах асуудлыг тусган хэрэгжилтийг ханган ажилладаг гэж дурдсан хэдий ч орон нутгийн удирдлагуудын иргэдийн оролцоог хангах чиг үүргийн хэрэгжилт харилцан адилгүй, хангалтгүй хэрэгжиж байна.

Орон нутгийн удирдлага ИНХ-ыг хуралдуулах, зохион байгуулах, иргэдийг мэдээллээр хангах үүргээ хангалттай хэрэгжүүлдэггүй, үнэлгээний танилцуулга, тайланг уншиж судлах, улмаар хурлын зар, үнэлгээний танилцуулга, мэдээллийг хүргэх зэрэгт ач холбогдол өгдөггүй, хурлын ирц бүрдүүлэх ажилд хүчин чармайлт гаргадаггүй гэж үнэлгээ эрхлэгчид үзэж байна.

Нөгөө талаас БОНБУ-ний талаарх орон нутгийн удирдлага болон иргэдийн ойлголт сул, орон нутгийн удирдлага, иргэд мэдээлэлтэй урьдчилан сайтар танилцаж, уншиж судлаагүйн улмаас хэлэлцүүлгийн зохион байгуулалт, асуулт хариулж, гаргаж буй саналын үр дүн хангалтгүй байдаг байна. Иргэдэд мэдээлэл дутмаг байдаг шалтгаан нь үнэлгээний төсөв мөнгөтэй холбоотойгоор иргэдэд мэдээлэл түгээх ажил хийгддэггүй, төсөл болон үнэлгээтэй холбоотой мэдээллийг иргэдэд өгөх сонирхол бага байна.

Энэ нь иргэдийн зүгээс сөрөг хандлага үүсэхээс болгоомжлох, үнэлгээний тайланг нууц гэж үзэх, иргэний хөдөлгөөн, Төрийн бус байгууллагаас болгоомжлох хандлагатай холбоотой байна. Иргэдэд танилцуулах хуудас, мэдээллийн хураангуйг бэлтгэн үнэлгээ эрхлэгч болон төсөл хэрэгжүүлэгч нар өөрсдөө тараах, цахимаар хүргэх тохиолдол цөөхөн байдаг байна. Ихэвчлэн орон нутгийн иргэд үнэлгээний явцын талаар мэдэхгүй явсаар нарийвчилсан үнэлгээ хийгдэж дуусаад ИНХ-аар хэлэлцүүлэх шатанд анх сонсдог, тэнд тараагддаг байдал нийтлэг байна.

Яамнаас ирүүлсэн мэдээллээр БОННУ-ний тайлангийн 1 хувийг төсөл хэрэгжих сум, дүүргийн ЗДТГ-т хүргүүлж, олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгөх боломжийг олгодог. Мөн төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ эрхлэгч, орон нутгийн удирдлагуудын үүрэг боловч орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах үүргээ хэрэгжүүлэхгүй байна. Харин хамтын оролцоотой Байгаль орчны мониторингийг холбогдох төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага, ТББ, иргэд болон төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран газар дээр нь хийх туршилтын ажлыг 2020 оноос эхлүүлж 2 аж ахуйн нэгж, байгууллага, 2021 онд 4 аж ахуйн нэгж, байгууллагад хийхээр төлөвлөсөн байна.

Үнэлгээний тайлан батлагдахаас өмнө иргэд уншиж танилцах боломж олгодоггүй, тайлан батлагдсаны дараа хуулийн дагуу орон нутагт хүргэгдсэн тайлантай танилцах, эсвэл байгаль орчны мэдээллийн сангаас цахимаар танилцах боломжтой байдаг нь орон нутгийн иргэд үнэлгээний талаар ойлголтгүй, ач холбогдол өгөхгүй байх нэг шалтгаан болж байна.

Хуулийг хэрэгжүүлэх хүрээнд гарсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”-ын хэрэгждэггүй болон хэрэгжилт хангалтгүй, практикт нийцэхгүй, тодорхой бус байгаа хэд хэдэн зохицуулалтад нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй гэсэн саналуудыг хяналт шинжилгээний явцад хийгдсэн ярилцлагуудад олонтаа дурдагдсан. Тухайлбал, журмын 2.7-д заасан “*Үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж нь төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссаны дараа үнэлгээний тайлан, олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авна*” гэдэг зохицуулалт огт хэрэгждэггүй тул бусад хуультай уялдуулах, үүрэг хариуцлагыг хуульчлан зохицуулах шаардлагатай байна.

Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулсан талаарх тоон мэдээлэл, хамрагдсан иргэдийн статистик тоон мэдээлэл одоогоор хариуцсан яаманд байхгүй байна. Статистик мэдээлэл одоогоор гаргах боломжгүй байгаа бөгөөд мэдээллийн санд оруулах ажлыг эхлүүлсэн байна.

Мөн БОНБУ-ний тухай хуулийн дагуу төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд олон нийтийн оролцоог хангасны дараа Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг, байгаль орчны чиглэлийн болон орон нутгийн Төрийн бус байгууллага оролцох эрхийг хязгаарладаггүй бөгөөд тухай бүрт хуралд оролцож, саналаа тусгах боломж нээлттэй байдаг гэсэн мэдээллийг яамнаас ирүүлсэн байна¹⁷.

БОНБУТ тухай хууль, холбогдох журмуудад олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг тусгахдаа үүрэг, хариуцлагын уялдааг хангаагүйн улмаас ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнөх үе шатны мэдээлэл өгөх, санал авах ажил орхигдох, бодит мэдээлэлд суурилсан оролцоог хязгаарлах зэрэг сөрөг үр дагавар гарч байна. Үүний зэрэгцээ үнэлгээ хийх төслийн ангилал хэт өргөн хүрээтэй, зарим жижиг, дунд хэмжээний төслүүдийн төсөв хэт бага, мөн үнэлгээ эрхлэгч компаниудын оролцоог хангах чадавх сул зэргээс шалгаалан оролцоог хангах байдал хэрэгжихгүй байна.

Тиймээс Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг зохион байгуулахад төсөл хэрэгжүүлэгч, орон нутгийн удирдлага тодорхой үүрэг хүлээж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, тухайн орон нутгийн удирдлагууд нь иргэдээ төлөөлөх үүргээ биелүүлж, хурлын ирц бүрдүүлэх, олон нийтийн оролцоог хангахад дэмжлэг үзүүлж ажиллах зэрэг оролцогч талуудын эрх үүргүүдийг тодорхой болгосон эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.

Хуульд заасны дагуу БОАЖЯ-ны байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан буюу <https://www.eic.mn/> цахим хаягаар дамжуулан стратегийн үнэлгээ хийгдэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдсан төслүүдийн талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлж байна.

Орон нутгийн удирдлага талаас үнэлгээний ажлын талаарх мэдээллийн хүртээмж хангалтгүй, ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнөх үе шатанд иргэдэд мэдээлэл өгөх, санал авах, хэлэлцүүлэг хийх үүргээ үнэлгээ эрхлэгчид хэрэгжүүлдэггүйгээс иргэдийн итгэл сулрах, ирц бүрдэхгүй байх, мэдээлэлгүйгээр хуралд оролцож, үр дүнтэй санал гаргаж чадахгүй байна гэсэн байр суурийг илэрхийлсэн. Тийм учраас мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг сайжруулах, иргэдэд БОНБУ-ний талаар мэдээлэл, сурталчилгаа хийх, иргэдээс авсан саналын үр дүнгийн талаар мэдээлэл авах боломжоор хангах, үнэлгээ эрхлэгчдийг орон нутагтай илүү ойр, төслийн үнэлгээний эхнээс хамтарч ажиллах, эргэх холбоог бий болгож ажиллах хэрэгтэй байна.

Иргэд өөрсдийн амьдарч буй нутаг орны онцлог, мэдлэг, туршлагаасаа хуваалцах, байгаль орчин болон эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэд үзүүлж буй болон төсөл хэрэгжсэнээр үзүүлж болох сөрөг нөлөөллийг бууруулах талаар ач холбогдолтой санал гаргаж тусгуулах, байгаль орчны хамгаалах, нөхөн сэргээлгэх талаар хамтран ажиллахад иргэдийн оролцоо чухал байтал манай иргэд ихэнхдээ тухайн төсөл хэрэгжүүлэгчээс орон

¹⁷ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 01/3987 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэл.

нутгийн бүтээн байгуулалт, худаг усны хангамж, хандив тусламж хүссэн санал хэлэх тохиолдол давамгайлж байна.

Нөгөө талаас иргэдэд мэдэх эрхийг нь хангаж байгаа боловч тухайн орон нутгийн иргэд биднээс зөвшөөрөл авах ёстой гэдэг байдлаар ойлгож, эсэргүүцэх, суулт зарлах, төсөл хөтөлбөрийг гацаах байдал их байна. Энэ нь иргэдийг төслийн болон үнэлгээний талаарх ойлголт, мэдээллээр хангах, БОНБУ-ний зорилго, ач холбогдлыг ойлгуулж, таниулах хэрэгцээ шаардлага их байгааг харуулж байна.

Үнэлгээ эрхлэгчдийн чадавх, хариуцлага сул, үнэлгээний тайлан хэт ерөнхий, өмнөх тайлангаас хуулбарласан, хоёрдогч эх сурвалжаас авсан мэдээлэл ашиглах, төсөл хэрэгжүүлэгч болон орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцээгүй, чанаргүй гүйцэтгэх, хэрэгжих боломж багатай зөвлөмж гаргадаг, үнэлгээ хийж буй үйл явц ил тод бус, хяналт тавих боломж бага байдаг учраас үнэлгээний тайлан хэрхэн боловсруулагдсан, түүнд олон нийтийн санал хэрхэн туссанг мэдэх боломжгүй, туссан эсэх талаар эргэж мэдээлдэггүй зэрэг үнэлгээ эрхлэгчидтэй холбоотой асуудлууд гарч байна.

Байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн холбоо болон мэргэжлийн байгууллагуудаас Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангахтай холбоотой эрх зүйн зохицуулалтад дараах асуудлууд, холбогдох санал, зөвлөмжийг гаргаснаас дурдвал:

1. Мэргэжлийн байгууллагуудын боловсруулсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд олон нийтийн оролцоог хангах, санал авах үйл ажиллагааг тухайн орон нутгийн удирдлагууд, иргэд, олон нийт нь тухайн төсөл хэрэгжих эсэхэд санал өгөх, зөвшөөрөл өгөх үйл ажиллагаа гэсэн буруу ойлголттой, байгаль орчны үнэлгээтэй холбогдуулж биш тухайн төсөлтэй холбогдуулж санал гаргадаг, эсэргүүцэл илэрхийлдэг асуудал байсаар байна;
2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний үе шатуудын дараалал нь уул уурхай, эрчим хүч, дэд бүтцийн төслүүдийн төлөвлөлт, зөвшөөрөл, бүтээн байгуулалтын үе шатуудтай зөрчилдөж төсөл хэрэгжүүлэгчид болон мэргэжлийн байгууллагуудад хүндрэл учруулдаг;
3. Мэргэжлийн байгууллагуудын боловсруулж батлуулсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч нар нь хэрэгжүүлж ажиллах биш БОАЖЯ-аар батлагдсан тамга тэмдэг бүхий зөвшөөрөл мэтээр буруу ойлгож ашигладаг нь тухайн төслийн сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах гарын авлага болохуйц судалгаа хийж нөлөөллийг үнэлж, бууруулах арга хэмжээнүүдийг зөвлөж тусгасан бичиг баримтын үнэ цэнийг алдагдуулж байна;
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангахдаа заавал иргэдийн нийтийн албан ёсны хурал хийхгүйгээр хэлэлцүүлэг, уулзалт, санал авах байдлаар зохицуулалт хийх, ингэхдээ төслийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, олон нийтийн оролцоог хангахад орон нутгийн удирдлага, байгаль орчны алба, хэлтэс, мэргэжилтнүүдийн үүрэг оролцоог бий болгох;
5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралт ерөнхий үнэлгээ хийх төслийн ангиллыг нарийвчлан шинэчлэн тогтоох, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны хэлбэрүүдийг ялгаатай тогтоох, үнэлгээний эхлэлээс батлагдах хүртэлх олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны хэлбэр, хугацаа, хариуцлагыг тодорхой болгох; Тухайлбал,

- Уул уурхай, томоохон үйлдвэр, эрчим хүч, дэд бүтцийн хөгжлийн төслүүдийн;
- Хэд, хэдэн аймаг, сумд, багийн нутаг дэвсгэрийг хамарсан газрын тос, уламжлалт бус ашигт малтмалын төслүүдийн;
- ХАА, Газар тариалангийн төслүүдийн;
- Үйлдвэрлэл, үйлчигээ, хот суурин газарт хэрэгжих төслүүдийн гэсэн ангиллаар БОННУ-нд олон нийтийн оролцоог хангах ялгаатай хэлбэрүүд болон шалгууруудыг тогтоож өгөх.

6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг тухайн төслийн төлөвлөлт, зөвшөөрөл, ТЭЗҮ, бүтээн байгуулалт зэрэгтэй уялдуулж, төсөл хэрэгжүүлэгч болон бусад оролцогч талуудын тодорхой үүрэг оролцоотойгоор зохион байгуулж байхаар эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт хийх зэрэг саналуудыг гаргасан.

Мөн БОНБҮТ хуулийн 18.2.-т *“Засгийн газрын хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үндэсний болон бүс нутгийн хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд стратегийн үнэлгээ хийх явцад олон нийтээс санал авна.”* гэж заасан ч 2012 оноос хойш байгаль орчны стратегийн үнэлгээ хийгдэж, Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн тохиолдол гараагүй байна.

Засгийн газраас 2012 оноос хойш үндэсний болон бүс нутгийн хэмжээнд баримтлах бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнүүд олноор батлагдан гарсан боловч тэдгээрт стратегийн үнэлгээ хийж олон нийтийн санал аваагүй байгаа нь хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага нь өөрөө стратегийн үнэлгээ хийгдээгүй, олон нийтийн санал аваагүй гэдэг шалтгаанаар бодлого, хөтөлбөрийг буцаах ёстой байтал дээрх заалтыг огт мөрдөж ажиллахгүй байна. БОАЖЯ-наас хуулийн хэрэгжилттэй холбоотой ирүүлсэн мэдээлэлд дурдсанаар бусад яамд болон төрийн байгууллагуудад холбогдох сургалтыг явуулж, албан тоот явуулдаг боловч хэрэгжихгүй байгаа шалтгаан нь төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байдагтай холбоотой байна.

ГУРАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН САНАЛ, ДҮГНЭЛТ

Улсын Их Хурлын Тамгын газраас БОНБҮТ хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ хийхдээ холбогдох мэдээллийг Байгаль орчин аялал, жуулчлалын сайдын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 01/3987 дугаар албан бичиг, МХЕГ-аас цахимаар ирүүлсэн мэдээлэл, БОНБҮТ хуулийн үзэл баримтлал зэрэг баримт бичгийн эх сурвалж болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах нь: Оролцогч талуудын судалгаа”, статистик тоо баримт зэрэг эх сурвалж, хуулийн хэрэгжилтэд өртөгч, уг харилцаанд оролцогч субъектуудээс тэнцвэртэй мэдээлэл авах зорилгоор БОАЖЯ-ны Байгаль орчны үнэлгээ, Аудитын хэлтсийн ахлах шинжээч, Байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн холбоо ТББ, үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгжийн төлөөлөл, удирдлагатай уулзалт, ярилцлага зохион байгуулж, мэдээлэл цуглуулан хуулийн хэрэгжилтийн байдал хяналт шинжилгээ хийлээ.

БОНБҮТ хуулийн хэрэгжилтийн явц зохих түвшинд хэрэгжиж байгаа хэдий ч хуулийн зарим зохицуулалтын хувьд төсөв санхүү, хүний нөөцийн чадавх, салбар хоорондын уялдаа, зохион байгуулалтаас шалтгаалан хангалттай түвшинд хэрэгжихгүй байна гэж үзэж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дараах санал, дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Мэргэжлийн зөвлөл хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж байгаа хэдий ч ажлын хэлэлцэх асуудлын тоо их, ажлын ачаалал их байдагтай холбоотой зарим хүндрэл

- бэрхшээл гарах, хуульд заасан хугацаатай чиг үүргүүдийн хэрэгжилт хангалтгүй байна;
2. БОАЖЯ-ны байгаль орчны үнэлгээ хариуцсан шинжээчдийн ажлын ачаалал их байдгаас ерөнхий үнэлгээг ажлын 14 хоногт багтаан хийх, нарийвчилсан үнэлгээний тайланд ажлын 18 хоногт багтаан шинжилгээ хийх, ажлын 28 өдөрт багтаан эрх олгох зэргээр хуульд тусгайлан хугацаа заасан зохицуулалт практикт хэрэгждэггүйгээс шалтгаалан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч болон үнэлгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүд хохирох тохиолдол гардаг байна;
 3. Хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш хуулийн 5 дугаар зүйлд заасан стратегийн үнэлгээ хийгдээгүй байна. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний цар хүрээ өргөн, төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжид эдийн засгийн хувьд ач холбогдолгүй, тухайн үнэлгээг зайлшгүй хийх эрх зүйн шаардлага сул зэргээс шалтгаалан хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийгдэхгүй байна;
 4. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх төслүүдэд тавигдах шаардлагыг том, жижиг бүх төслүүдэд ижил түвшинд тавьсан нь бодит байдалд хэрэгжих бололцоо муу, үнэлгээ хийхэд хүндрэл учруулах, ач холбогдол багатай баримт бичгүүдээр төсөл хэрэгжүүлэгчдэд чирэгдэл болсон, дарамт учруулдаг тул үнэлгээний ангиллыг нарийвчлан зааглаж шаардлагатай байна;
 5. Төсвийн байгууллагын зардлаас хамаараад хяналт шалгалтыг олон давтамжтай хийх боломж хомс байдаг нь хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сулруулж байна.
 6. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгаль орчны нөхөн сэргээлтийн тусгай дансанд барьцаа хөрөнгийг бага байршуулдгаас шалтгаалан байгаль орчны нөхөн сэргээлт хийгддэггүй, аж ахуйн нэгж байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна.
 7. Олон нийтийн оролцоог хангах талаар тайланд дурдсан асуудлуудаас дүгнэхэд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн олон нийтийн оролцоог хангах талын зохицуулалтууд болон хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд гарсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”-ын хэрэгжилт хангалтгүй, хуулийн үзэл баримтлалаар дэвшүүлсэн зорилго хангагдахгүй байна.
 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахгүй байгаагийн шалтгаан нь тухайн зөрчилд оногдуулах хариуцлагын хэмжээ 500,000 төгрөг буюу хэт бага байгаад анхаарч, бодит нөхцөлд тохируулан нэмэгдүүлэх;
 9. Үнэлгээ хийх эрхтэй аж ахуйн нэгжийг чадавхжуулах, үнэлгээний үр дүн, ач холбогдлыг нэмэгдүүлэхэд дан ганц үнэлгээ эрхлэгчдийг аттестатчлахаас гадна байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг шинээр олгоход тавигдах шалгуурыг нэмэгдүүлэх;
 10. Үнэлгээний эрх олгох, сунгах, түүнчлэн нарийвчилсан үнэлгээний шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гаргаж, төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх зэрэгт яамны мэргэжилтнүүд ашиг сонирхлын зөрчилтэй байр сууринаас хандах, өөрийн хамаарал бүхий аж ахуйн нэгжээр төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэх сонирхолтой байх, ашиг сонирхлын болон бусад шалтгаанаар үнэлгээний тайланг батлахгүй удаах, цаг хугацаа алдуулах зэргийг хязгаарлахад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

11. Хариуцсан яам, Мэргэжлийн зөвлөл болон орон нутгийн удирдлагууд олон нийтийн оролцоог хангаж чадаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх, хэрэгжилтэд хяналт тавих, улмаар олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн бодлого, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах;
12. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг зохион байгуулахад төсөл хэрэгжүүлэгч болон орон нутгийн удирдлагууд, мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллах, тухайн орон нутгийн удирдлагууд нь иргэдээ төлөөлөх үүргээ биелүүлж, хурлын ирцийг бүрдүүлэх, олон нийтийн оролцоог хангахад дэмжлэг үзүүлж ажиллах зэрэг оролцогч талуудын эрх үүргийг тодорхой болгосон эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
13. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралт байгаль орчны ерөнхий үнэлгээ хийх төслийн ангиллыг нарийвчлан шинэчлэн тогтоох, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны хэлбэрүүдийг ялгавартай тогтоох, томоохон төсөл, хөтөлбөрийг яамны түвшинд, жижиг төсөл, хөтөлбөрийг харьяа орон нутагт нь хариуцуулах замаар үүрэг, хариуцлагыг тодорхой болгох;
14. Үнэлгээний талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, улмаар үр дүнтэй санал гаргах боломжоор хангах, ИНХ-аар хэлэлцүүлэхээс өмнө иргэдээс санал авч, мэдээллээр хангах, олон нийтийн санал туссан эсэх талаар эргэж мэдээлэх замаар олон нийтийн үр дүнтэй оролцоог хангаж, БОНБУ-ний зорилго, ач холбогдлыг ойлгуулах.

---oOo---